

**Х.Дэлгэр:** Банк итгэлцлэлийн байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа нь итгэл дээр тогтдог учир их эмзэг байдаг

*1990-ээд оноос хойш хоёр шатлалт банкны систем албан ёсоор үүсч хөгжсөн гэж үздэг. Энэ хугацаанд үйл ажиллагаа явуулж байсан хэд хэдэн банкууд ч дампуурч байсан удаатай. Монголбанкны Хяналт шалгалтын газрын Зайнаас хяналт тавих хэлтсийн захирал Х.Дэлгэртэй банкны системийн үйл ажиллагааны талаар ярилцлаа.*

**-Монгол Улсад банкны салбар үүсч хөгжөөд 87 жилийн хугацаа өнгөрчээ. Арилжааны банкуудад хяналт тавьж ажилладаг Хяналт шалгалтын газрын үйл ажиллагааны талаар танилцуулбал?**

- Монголбанкны Хяналт шалгалтын газрын үйл ажиллагааг ярихаас өмнө хяналт шалгалтын талаар товч танилцуулах хэрэгтэй байх. Монгол Улсад банкны салбар үүсч хөгжсөөр бараг 90-н жил болох гэж байна. 1924 оны зургадугаар сард анх Монгол Оросын хамтарсан Худалдаа аж үйлдвэрийн банк нэртэйгээр одоогийн Монголбанк байгуулагдаж байсан түүх бий. Үүнээс хойш 1954 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр тухайн үеийн БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн “Монголын худалдаа аж үйлдвэрийн банкиг БНМАУ-ын Улсын банк болгон өөрчлөн байгуулах” тухай 120 дугаар тогтоол гарч улмаар БНМАУ-ын Улсын банкны дүрэм батлагдан үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж эхэлсэн байдаг. Улсын банкны дүрэмд зааснаар “Улсын байгууллагуудын харьяа нэгжүүдийн ажил хэргийг Улсын банкны ерөнхий хорооны дарга буюу түүний орлогчийн захиргаанд байгаа Шалган байцаах хэлтсээс шалган байцаана” гэж заасан нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн нөхцөлд улс орны мөнгөн гүйлгээ санхүүгийн нөөцийг төвлөрүүлэн зөв зохицуулахад банкнаас төрөл бүрийн хяналт тавигдах үндсэн бүтцийг бий болгосон гэж үздэг. Ийн явсаар 1991 оноос Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр Төв банк|Монголбанк|, арилжааны банк гэсэн хоёр шатлалт банкны систем бүрэлдэн бий болж үйл ажиллагааг нь тус тусын дүрмээр зохицуулж эхэлсэн. Энэ үеэс эхлэн Монголбанкнаас зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байгаа банкуудад хяналт тавих эрх үүрэг бүхий өмнөх бүтэц дээр суурилсан Монголбанкны нэгж бий болсон. Тэр нь манай Хяналт шалгалтын газар юм. Одоо Хяналт шалгалтын газар нь гурван хэлтэс, хоёр нэгж, 50 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Өнөөдөр дэлхийн улс орнуудад санхүүгийн хоёр том систем өрсөлдөж байгаа бөгөөд Банк давамгайлсан санхүүгийн системийн бүтэцтэй улс /Герман, Япон/, Банкнаас бусад санхүүгийн институци давамгайлсан системийн бүтэцтэй улс/АНУ, Их Британи/-ууд гэж ангилж байна. Манай улсын хувьд банк давамгайлсан санхүүгийн систем нь илүү хөгжиж ирсэн орон. Үүний хамгийн тод жишээ нь сүүлийн 20 гаруй жил явж ирсэн санхүүгийн салбарын бүтэцээс харахад л тодорхой байдаг бөгөөд өнөөдөр банкны систем нийт санхүүгийн системийн 95 хувийг дангаараа эзэлж байгаагаас харж болно. Бусад таван хувь нь санхүүгийн бусад байгууллага, даатгал, хадгаламж зээлийн хоршоо, хөрөнгийн зах зээл эзэлж байна. Банкны системийн энэхүү ололт амжилт нь амаргүй замыг туулж өнөөдөртэй золгосон.

Манай улсын хоёр шатлалт банкны системийн хувьд 1991-1994 оны хооронд олон тооны банкууд Монголбанкнаас тусгай зөвшөөрлөө авч үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн

хөгжлийн эхэн үе байдаг. Энэ үеэс шинээр үүсч бий болсон олон тооны банкуудын удирдлагууд харилцагч, хадгаламж эзэмшигчдийг өөрийн банкиндаа татах өрсөлдөөн бий болж эх үүсвэр татахын тул харилцагчдад өндөр хүү амлах, улмаар өндөр хүүтэйн дээр барьцаа баталгаа нь шаардлага хангахгүй зээл их хэмжээгээр олгох, үүнийг дагаад өндөр хүүтэй зээл авсан зээлдэгчид зээл болон хүүгээ төлөх чадваргүй болж чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх зэрэг зээлийн эрсдэл үүсч эхэлж байсан. Жишээ нь тэр үеийн зээлийн гэрээ нь Иргэн Доржид нэг сая төгрөгийн зээл олгов гэсэн ганц хуудас цааснаас өөр нотлох баримт олдохгүй тохиолдол нийтлэг байсан. Мөн харилцагчид нь нэмэгдэхийн хэрээр банкуудын салбар нэгжийн тоо асар хурдтайгаар нэмэгдэж эдгээрт банкны төвөөсөө тавих хяналт, удирдлага алдагдсанаар банкуудын байдал хүндэрч эхэлсэн байдаг. Энэ үеэс л Монголбанкны Хяналт шалгалтын газрын үүрэг банкны системд улам ихээр шаардлагатай болж эхэлсэн. Ер нь банкны системийн хөгжлийн түүхээс харахад хяналт шалгалтын үүрэг функц нь банкны системтэйгээ салшгүй холбоотой явж ирсэн байдаг. Учир нь банкны систем өрөө мөнгийг эргэлдүүлж байдаг тул мөнгө байгаа газарт хяналт байх нь хууль юм.

### **-Тухайн үед хэд хэдэн банк дампуурч байсан байх аа?**

-Илүү тодорхой ярья. Сүүлийн 20 гаруй жилийн түүхээс харахад манай банкны системийн үйл ажиллагаанд муугаар нөлөөлсөн 3 удаагийн том хямрал нүүрэлсэн гэж үзэж болно. Анхных нь миний дээр хэлсэн 1990-ээд оны банкны систем бүрэлдэн бий болж байсан эхэн үеийн эрх зүйн зохицуулалтгүй орчинд өндөр хүүтэй хадгаламж татаж, барьцаа баталгаагүй өндөр хүүтэй зээлийг байгууллага иргэдэд их хэмжээгээр олгож, зээлдэгчид нь зээлсэн мөнгөө банкинд төлж чадахгүй болсноос банк, хадгаламж эзэмшигчид, харилцагчдынхаа мөнгөн хөрөнгийг анхны шаардлагаар нь буцаан олгох төлбөрийн чадваргүй болж банк санхүүгийн хүндрэлд орж эхэлсэн байдаг. 1994 оноос эхлээд хэд хэдэн банк нэгдэх, татан буугдах болж улмаар Их зам, Төв ази банкууд татан буугдсан. Энэ үеэс Монголбанк банкны системийн эрх зүйн шинэчлэл хийж эхэлсэн бөгөөд Төв банк|Монголбанк|-ны тухай болон Банкны тухай бие даасан хуулиудыг 1996 онд Монгол улсын их хурлаар батлуулж, шинээр бүрдсэн эрх зүйн орчинд банкуудын бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэн төлбөрийн чадварын хүндрэлд орсон Ард банк, Даатгал банкуудыг татан буулгаж, энэхүү бүтцийн өөрчлөлтийн хүрээнд Хадгаламж, Сэргээн босголтын банк гэсэн цоо шинэ 2 банкиг төрийн өмчит хэлбэрээр үүсгэн байгуулж байсан. Яг энэ үед 1997 оны Солонгосын хөрөнгийн биржээс үүдэлтэй Азийн санхүүгийн хямрал манай орны эдийн засагт нөлөөлж эхэлсэн бөгөөд энэ нь 2 дахь удаагийн том хямралын эхлэл байсан. Банкны системийн эрх зүйн орчин дөнгөж бүрэлдэн бий болж байсан, банкуудын үйл ажиллагаа жигдрээгүй байсан, төрийн оролцоо банкны дотоод үйл ажиллагаанд хэт орсон байсан зэрэг гадна дотны нөхцөл байдлаас шалтгаалан 1998 онд Сэргээн босголтын банк, ХОТШ банкууд дампуурч үйл ажиллагаагаа зогсоосон. Энэхүү хямралаас сургамж авч Монголбанк банкны бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэн тухайн үед банкуудын үйл ажиллагаанд зохистой харилцааны шалгуур үзүүлэлтүүдийг мөрдүүлэх аргачлалыг шинээр нэвтрүүлэх, банкуудын дүрмийн сангийн хэмжээг шат дараатай өсгөх, зээлийн мэдээллийн санг бий болгох, зээлийн ангилал хийж эрсдлийн санг байгуулах зэрэг бодлогын цоо шинэ арга хэрэгслэлүүдийг системд нэвтрүүлж эхэлсэн. Саад бэрхшээл байсан ч Монголбанкнаас шат дараатай авч хэрэгжүүлсэн арга хэмжээ,

бодлогын үр дүнд 2000 оноос эхлэн банкны систем эрчтэй хөгжиж, 2000-2008 он гэхэд 17 банкттай, банкны системийн нийт актив нь 225 тэрбум төгрөгөөс 2,5 их наяд төгрөгт хүрсэн байсан бол өнөөдөр 9.4 их наяд төгрөгт хүрч, үүнээс зээл 5.6 их наяд төгрөг, хадгаламж 3.8 их наяд төгрөгт хүрээд байгаагаас банкны системийн зуучлал хэрхэн өссөнийг харж болноо.

**-2008 оны дэлхийн санхүүгийн хямралаас болж мөн хоёр банк үүдээ барьсан гэж ойлгож болох уу?**

-2008 оны АНУ-ийн санхүүгийн корпорациас үүдэлтэй мортгейжийн гэгдэх дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямрал манай улсын санхүүгийн системд шууд биш ч шууд бусаар нөлөөлсөн нь үнэн. Эндээс нэг зүйл анзаарагдаж байгаа нь эдийн засаг мөчлөгөөр явагддаг гэдгийг батлах мэт ойролцоогоор 8-10 жилийн үечлэлтэйгээр манай улсын банкны системд хямрал тохиолдсон дүр зураг харагдаж байна. Гайхалтай нь эдгээр хямрал мөн л цаг хугацааны хувьд дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямралуудтай давхцаж байгаа нь анзаарагддаг. Манай улсын санхүүгийн системд тохиолдсон сүүлийн хямрал нь банкуудын гүйцэтгэх удирдлага, төлөөлөн удирдах зөвлөл, хувь нийлүүлэгчдийн хариуцлага, зохистой удирдлагын зарчим, системийн ажилтнуудын ёс зүй хэм хэмжээг хэрхэн мөрдөж байгаа зэргийг шалгасан хямрал байсан гэж дүгнэж болохоор байна. Монголын банкуудын хувьд энэхүү хямралыг харьцангуй хохирол багатай давж гарсан ч харамсалтай нь “Зоосбанк ХК”, “Анодбанк ХК” гэсэн хоёр хувьцаат компани дампуурч одоо хуулийн дагуу татан буугдах үйл ажиллагаа эцэслэн хийгдэж байгаа нь ч сонин тохиолдол юм. Дээрх хямралууд нь тухай бүр системд дархлааг бий болгож, дараа дараагийн хямралуудад банкуудыг бэлтгэлтэй байлгахыг сануулахын зэрэгцээ өөр өөрийн онцлог сургамжуудыг үлдээсэн байдаг.

**-Банкууд дампуураад ирэхээр иргэдийн банкинд итгэх итгэл буурах хандлагатай болж эхэлдэг одоо банкуудын байдал ямар байна вэ?**

-Тухайн үед дэлхийн хэмжээний санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг байсан байгууллага дампуурлаа зарласан нь ганц манай улсад ч биш дэлхий нийтэд их бага хэмжээгээр нөлөөлж эхэлсэн. Манай улсын хувьд байгууллага иргэдийн банкинд итгэх итгэл сулрах болсон нь ажиглагдаж 2008 оны эхнээс гадаад дотоодын харилцагчид банкнаас мөнгөө эрчтэй татаж, мөнгө системээс гадагшлах урсгал нэмэгдсэн. Ер нь Банк итгэлийн байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа нь итгэл дээр тогтдог учир банкны систем өөрөө их эмзэг байдаг. Энэ цаг үетэй давхцан санаатай болон санамсаргүйгээр банк дампуурах нь гэсэн цуу яриа харилцагчдыг сандралд оруулж эхэлсэн. Харин энэ үед Монголбанк, Засгийн газрын санаачилсан Монгол улсын их хурлаас 2008 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр **Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийг** баталж гаргасан нь санхүүгийн системийн хувьд асар том дэм үзүүлсэн зоригтой шийдэл болсон гэж үзэж байна. Хууль хэрэгжиж эхэлснээр байгууллага иргэдийн банкинд итгэх итгэл эргэн сэргэж системээс мөнгө гадагшлах урсгал зогссон бөгөөд 2009 оноос эдийн засаг аажмаар сэргэж эхлэхтэй зэрэгцэн банкны хуримтлал асар хурдацтайгаар өссөн үр дүн гарсан. 2008-2010 оны хагас жил хүртэл системийн өсөлт зогсонги байсан бөгөөд дээрх өсөлттэй холбоотойгоор 2010 оны хагас жилээс эхлэн банкны системийн харилцах

хадгаламжийн хэмжээ асар хурдацтайгаар өсч эхэлсэн байдаг. 2011 оныг өнгөрсөн онтой харьцуулахад банкны систем 60 хувиар өссөн нь банкуудад нийтлэг мөрдөгддөг зохистой харьцааны үзүүлэлтүүдээ хангаж эхэлсэн, заавал байх нөөц, төлбөрийн чадварын үзүүлэлтүүдээ ханган ажиллаж байгаа нь банкуудын үйл ажиллагаа тогтворжсоны нотолгоо гэж үзэж болно. 2008-2009 онуудад нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 11-18 хувьтай байсан бол 2011 оны сүүл гэхэд 4 хувь болж буурсан үзүүлэлттэй байгаагаас харахад Монголбанк банкуудын үйл ажиллагааны зохицуулалтаа хэрхэн цаг үед нь нийцүүлэн хийж байгаа нь харагдах байхаа.

**-Банкны үйл ажиллагааг сайжруулах, баталгаатай үргэлжлүүлэх тал дээр Монголбанкнаас ямар арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна вэ?**

2010 оны нэгдүгээр сард Монгол улсын их хурлаас банкны системийн эрх зүйн орчинг сайжруулах, өнөөгийн нийгэм эдийн засгийн болон олон улсын нөхцөл байдалтай уялдуулан Төв банк|Монголбанк|-ны тухай болон Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгийг баталсан. Энэ хуульд Компанийн зохистой засаглалын зарчим, Банкны ил тод байдал, Банкны үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх, Хөрөнгийн захыг банкуудад нээлттэй болгох, дэд бүтцийг бүрдүүлэх зэрэг гол асуудлуудыг тусгаж өгсөн. Ингэснээр банкууд мэдээллээ нийтэд ил тод нээлттэй мэдээлэх асуудлыг хуульчилж өгсөнөөр иргэд олон нийт аль нэгэн төрийн байгууллагад хандаж бус харин банкуудаас хүссэн мэдээллээ шууд авах боломж бүрдсэн. Мөн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 726 дугаар тушаалаар банкны системд нөлөө бүхий банкуудийг нэрлэж эдгээр банкуудад тавигдах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бусад банкуудтай харьцуулахад илүү хатууруулж банкны системийн тогтвортой найдвартай байдлыг хангах зэрэг арга хэрэгслийг шат дараалан авч хэрэгжүүлээд байна.

**-Сүүлийн 20 жилд эрчимтэй хөгжсөн банкнууд өнөөдөр хэвийн үйл ажиллагаа явуулж чадаж байна уу. Сүүлийн үед зарим банкнийг дампуурна гэх яриа гараад байгаа?**

-Банкуудын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа, банкууд зуучлалын үүргээ сайн биелүүлж байна гэж хэлж болно. Манай Зайнаас хяналт тавих хэлтэс маань банкуудын өдөр тутмын үйл ажиллагаанд мониторинг хийж, сар, улирал, жилээр банкуудаас тайлан тэнцэл, зохистой харьцааны үзүүлэлтийн биелэлтийг гаргуулан авч нэгтгэн үнэлэлт дүгнэлт өгч ажилладаг. Би дээр хэлсэн банк итгэлцлэлийн байгууллага, иймд энэ систем их эмзэг байдаг гэж. Сая чиний асууж байгаа тэр банк дампуурах гэнэ гэсэн цуу яриа ч юм уу эсвэл банкны мөн чанарыг ойлгохгүй мөртлөө санаатай болон санамсаргүй хэлсэн хэн нэгний хариуцлагагүй ганц үг өгүүлбэр, мэдэгдэл нь тухайн банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй системийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх хор уршигтай байдаг. Энэ нь цаашлаад улс орны эдийн засагт нөлөөлж, та бидний өөрсдийн амьдралд сүүдрээ тусгах магадлал өндөртэй байдгийг хэн ч байсан санаж явахад илүүдэхгүй болов уу гэж бодож байна.